

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-13 сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

ӨЭЛҮН ЭХ

“Алив охин минь, энэ утасны ээдрээг гаргаад орхи!” гэж Өэлүн эх хэлээд, ширдэг дээр овоолсон торгон утасны зүг заалаа. Бөртэ хатан ойрдоо хийгээгүй ажилд баахан тээршээвч утсыг өвөр дээрээ аваад, махлаг хуруугаараа сэмлэн ялгах зуур өөр лүүгээ ширтэн буй хадам эхийн харцыг мэдэрч, түгшин эмээж суужээ.

“Иймэрхүү ажлаас сүрхий төсөөрөх нь дээ, чи минь” гэж эх хэлснээ, “Чиний буруу алга. Эзэн эр чинь өнөө Хар тэргүүтний хаан. Тийм болохоор чи утас ялгах биш, ширэлдэн холбогдсон тэр олон ихсийн үг санааг ялган тунгаах илүү бэрх ажилтай хүн шүү дээ” гэж үгээ залгахад нь Бөртэ аг чиг сууж, Тэмүүжинтэй дэр нэгтгэхээс өмнө энэ хатуу чанд эхийн зовон зүдэж яваа сургийг сонсож, аймсан байснаа дурсана. Есүхэй баатрын нас нөгчсөнийг дуулаад, эцэг Дэй сэцэн нь охиныхоо хувь тавиланд хэрхэн түгшиж байгааг Бөртэ гадарласан. Нэгэнтээ Тэмүүжиний гэрт очно гэдгээ мэдэж байсан болохоор охин өөрөө ч Есүхэйн хөвгүүдийн сургийг шимтэн чагнадаг байжээ.

...Одоо Бөртэгийн дэргэд суугаа зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэйд тэр үеийн Өэлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон ажаам.

“Эдэрсэн утсыг тэвчээрээр эвт нь оруулахаас бус, хүчээр хийж хэрхэвч үл болох. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой. Ганц хайрлалтай нь үүнийг санах эхнэр даанч ховор. Харин чи өөр хүн. Хөвгүүдийн чинь зан ааль надад их л сайшаагдана. Өгөөдэй, Толуй хоёр төвшин болоод нягт чамбай. Гэвч...чи, Тэмүүжин хүүг минь баахан мартсан мэт...” Энэ үгэнд Бөртэ ичих, цочих хосолж эхийн зүг харвал Өэлүн инээмсэглэсэнгүй харц нь сүрхий шаардах өнгөтэй. Бөртэ толгой бөхийж:

“Эх өршөө. Хүү тань өнөө их бага олон аймгийг хамтатган захирсан хаан бус уу. Түүнийг сурган залах гэгч яахан санаанд багтана” гэвэл, Өэлүн шүүрс алдаад: “Чухамдаа гэрийн гаднах үйл бидэнд хамаагүй. Гэвч дотоод, гадаад ажил цөм нийлж, нэгэн айлын үйлс болдог. Айл гэрээс үл хамаарах төр гэж үгүй. Би чамайг эрх мэдэлдээ олтгойрох хүн гэж ер үл бодном. Гагцхүү эзэн эрийнхээ ааш занг хөвгүүдийнхээсээ багагүй ажиж байгаасай гэж хүснэ. Эртнээс сургаснаар арга билиг гэгч энэ бөлгөө. Арга гэж нар болой. Нар гэгч эр. Эрийн чанар хатууд түшжээ. Тэгвэл билиг гэгч сар буюу эм. Эмийн чанар зөөлнийг эрхэмлэнэ. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно” гэв...

Т. Мандир

1. Өэлүн эх Бөртэ хатанд хандан “Утасны ээдрээг гаргаад орхи” гэж хэлсний учир юу вэ?
 - A. Оёж шидэх үйл үйлдэхэд утас нь байнга ээдэрч орооцолдоод болохгүй байсан учраас
 - B. Их хааны эх болон хатдын дунд зөрчил маргаан байнга гараад байсан учраас
 - C. Үр хөвгүүд, эзэн эрээ эвтэй, хүчтэй байлгах арга ухааныг сургамжилъя гэсэн учраас
 - D. Ураг удмын ахан дүүс нь хоорондоо эвлэхгүй их харгалдаантай байсан учраас
 - E. Бөртэ хатан ойрдоо огт ажил хийхгүй цааргалж, хойшлуулаад байдаг болсноос
2. Аль өгүүлбэр нь Бөртэ хатан Өэлүн эхийн зүдэж буйг мэдсэн цаг хугацааг илэрхийлж байна вэ?

- A. Хатан ойрдоо хийгээгүй ажилд баахан тээршээсэн.
 B. Тэмүүжинтэй дэр нэгтгэхээс өмнө сургийг сонсож байсан.
 C. Нэгэнтээ, Тэмүүжиний гэрт очно гэдгээ мэдэж байсан.
 D. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил.
 E. Зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэй.
3. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 1. ээдрээ a. чимээ аниргүй
 2. аг чиг b. бэрхшээх, төвөгшөөх
 3. тээршээх c. ширэлдэж орооцолдох
 4. аймсах d. үймэрч уймрах
 A. 1c, 2b, 3a, 4d B. 1a, 2b, 3c, 4d C. 1c, 2a, 3b, 4d D. 1c, 2d, 3b, 4a E. 1d, 2b, 3a, 4c
4. Эхийн сэдвийг сонгоорой.
 A. Их Монгол улсын хүчирхэгжсэн тухай
 B. Чингис хаан олон аймгийг нэгтгэсэн тухай
 C. Бөртэ хатны ухаажин, урамшиж буй тухай
 D. Ээдэрсэн утасны орооцолдоог гаргах тухай
 E. Эх хүний эрхэм нандин сургаалын тухай
5. Эхийн гол санаанд тохирох хэлц аль нь вэ?
 A. Ёсыг ёроолоос нь, учрыг угаас нь
 B. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй
 C. Бие шулуун бол сүүдэр буруугүй
 D. Сэтгэл сайхан бол өнгө нь сайхан
 E. Ёсчлон явбал хурчлан бууна
6. Зохиогчийн хэлэх гэсэн санааг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
 A. Чухам ээдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой.
 B. Чухамдаа гэрийн гаднах үйл бидэнд хамаагүй.
 C. Дотоод, гадаад ажил цөм нийлж, нэгэн айлын үйлс болдог.
 D. Айл гэрээс үл хамаарах төр гэж үгүй.
 E. Би чамайг эрх мэдэлдээ олтгойрох хүн гэж ер үл бодном.
7. “Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам ээдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой. Ганц хайрлалтай нь үүнийг санах эхнэр даанч ховор. **Харин** чи өөр хүн.” гэсэн өгүүлбэрт байгаа эсрэгцүүлэн холбох үг ямар үүргээр орсон бэ?
 A. Эрх мэдэлдээ олтгойрдоггүй шинжийг тодруулах
 B. Бөртэ бусад хатдаас илүү тэвчээртэйг тодруулах
 C. Хөвгүүдээ төвшин болоод нягт нямбай болгож хүмүүжүүлснийг тодруулах
 D. Үр хүүхдээ зөв үйлд сургаж байгааг тодруулах
 E. Ээдэрсэн утсыг салгах мэт хичээдэг ухаалаг болохыг тодруулах
8. “...Одоо Бөртэгийн дэргэд суугаа зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэйд тэр үеийн Өэлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон ажаам” гэсэн хэсгээс зохиогчийн үнэлгээ дүгнэлтийг илэрхийлэх хамгийн чухал үг хэллэгийг олоорой.
 A. наснаас эрт өтөлсөн буурал эмэгтэй
 B. өнгө жавхаа алга болсон ч сөргөхийн аргагүй
 C. зөөлөн харцтай, буурал эмэгтэй
 D. үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон
 E. сургамжтай үгс нь хэвээрээ
9. “Ээдэрсэн утас” гэсэн дүрслэлийн далд утгад тохирох нь аль вэ?
 A. Утас ялгах биш, ширэлдэн холбогдсон ихсийн үг санааг ялган тунгаах
 B. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил.

- С. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам ээдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой.
- Д. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно.
- Е. Өгөөдэй, Толуй хоёр төвшин болоод нягт чамбай.
10. "...Өөр лүүгээ ширтэн буй хадам эхийн харцыг мэдэрч, **түгшин эмээж** суужээ" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль хэлцээр солин найруулбал тохирох вэ?
- А. айхаа арьсанд боох В. зүрх алдах С. зүрх амаар гарах
D. зүрх догдлох E. зүрх гаргах
11. Төгсгөлийн цогцолборт байгаа үг хэллэгийн дарааллыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг сонгоорой.
- их бага, эрх мэдэл, дотоод гадаад, айл гэр, нар сар, ааш зан,
- А. хувь тавилан
B. өнгө жавхаа
C. арга билиг
D. хатуу чанд
E. үр хөвгүүд
12. Өгүүлбэрт онцолсон баймж бүтээвэртэй ойролцоо утгатай нөхцөлийг олоорой.
- Өэлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ.
- А. –соор В. -ж С. -оод D. -н E. -вч
13. "Ээдэрсэн утсыг тэвчээрээр эвт нь оруулахаас бус, хүчээр хийж хэрхэвч үл болох. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам ээдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой" гэсэн хэсэгт ямар өнгө аяс илэрч байна вэ?
- А. биширсэн В. хөөрхийлсөн С. халагласан D. сургамжилсан E. бахархсан
14. "Гэвч... чи, Тэмүүжин хүүг минь баахан мартсан мэт" гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ?
- А. Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн.
B. Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
C. Мэгдэж түгдэрсэн тул цуваа цэг хэрэглэсэн.
D. Эш татсан зүйлийн энд тэндээс орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
E. Зохиолын том бүлэг, их хэсгийг орхисон тул мөрлөсөн цэг хэрэглэсэн.
15. Ойролцоо утгатай үг бүхий хэлцийг олоорой.
- А. Баруун чихээр ороод, зүүн чихээр гарах
B. Надад инээд, чамд ханиад
C. Сайн эр урдаа шархтай, муу эр хойноо шархтай
D. Гэмтэйгээс гэтэлгэсэн, гайтайгаас гаргасан
E. Торгон дээлтэй хүнийг бөөлжихөд өрмөг дээлтэй хүн ч жигшинэ
16. Дээд найруулгын зэрэг бүхий өгүүлбэрийн сонгоорой.
- А. Нарны гэрэл тооноор тусаж, гэрт гэгээ нэмнэ.
B. Нарт тэнгэрийн дор насад энх амьдарна.
C. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно
D. Туурга нэвт туяатай, гэр нэвт гэгээтэй.
E. Нар шиг мандаж, сар шиг гэрэлтэнэ.
17. "ч" бүтээвэр нь зэрэгцүүлэн онцлох утга ялгаж байгаа хэсгийг олоорой.
- А. Яавч засрахгүй яриатай хүн шүү.
B. Малч хүний гярхай чанар өөр юм.
C. Бид эндээс гарч, тэднийг дагууллаа.
D. Чихэр амттай боловч жингээр идэж болохгүй.

- Е. Багш ч ирлээ, бид ч цуглалаа.
18. Ихэсгэж хэтрүүлсэн дүрслэл бүхий өгүүлбэрийг сонгоорой.
- A. Ерэн алд биетэй, есөн төө чихтэй...
 B. Туулай сайхан зоотой, дугариг сайхан хүзүүтэй...
 C. Туг сайхан сүүлтэй, тугал хар нүдтэй...
 D. Ан шувуундаа унадаг их хар морьтой...
 E. Хас эрдэнэ шүдтэй, халир мөнгөн уруултай...
19. “Ширнэн гуай **сүүлдээ** манай ажлын газар жижүүр хийдэг болсон юм” гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүний утга, үүргийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. . “жижүүр” гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 B. “манай ажил” гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 C. “хийдэг болсон юм” гэснийг хугацааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй
 D. үйлийн эзний утга илэрхийлсэн гол гишүүний үүрэгтэй.
 E. “ажлын газар” гэснийг шинж чанарын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
20. Нийлмэл үгийн бүтсэн аргыг ажиглаад цэгийн оронд тохирохыг сонгоорой.
 Аз жаргал, төмөр зам, эрч хүч, туулайн бөөр,.....
- A. ган зам B. эрүү толгой C. модон байшин D. цэцгийн дэлбээ E. санааны чимэг
21. Төрөл биш үгийг олоорой.
- A. тууварла B. туувар C. тууварчин D. туугч E. туурга
22. Үндсэн утгаараа байгаа холбоо үг аль нь вэ?
- A. нүд алдах B. сэтгэл алдах C. морь алдах D. шүүрс алдах E. ам алдах
23. Дуурайх язгуур бүхий үгийг олоорой.
- A. шархийх B. хазайх C. далийх D. муруйх E. сарийх
24. Эдгээр үгэнд бүтээвэр залгаж бичихэд гийгүүлэгч нэмэгдэх үгийг олоорой.
- A. дуусах+ын B. орон+ы C. байшин+ийн D. ээлж+ийн E. гадна+ы
25. Бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.
- A. тэмээчний, нутгийн, нөхцөлөөр B. харчхаад, эмээллээ, товчилбол
 C. түүхчдийг, тооцуулашгүй, сарнишгүй D. нисч, гэсч, дуусч
 E. нутгийнханы, харуусаж, нөхөгдшгүй
26. “**ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ** ᠖ ᠘᠙᠙” гэсэн холбоо үгийг зөв уншаарай.
- A. атаачны хөө B. адуучны гүү C. атаачны хүү D. адуучны хүү E. адуучны хөө
27. “ой” гэсэн үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцөл дагуулсныг олоорой.


A.	B.	C.	D.	E.
ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ
ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ	ᠣᠢ

28. Зөөлөн дэвсгэрээр төгссөн хэсгийг сонгоорой.






A.	B.	C.	D.	E.
ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ
ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ	ᠠᠨᠢᠨᠠᠨᠢ

29. Тодотгон холбох нөхцөлөөр зөв хувилгасныг олоорой.




A.	B.	C.	D.	E.
----	----	----	----	----



30. Уншаад холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

A. 
 B. 
 C. 
 D. 
 E. 






31. Уншаад зөв харгалзуулсан хэсгийг сонгоорой.

1. 
 2. 
 3. 






a.Австрали
 b.автомат
 c.автобус

A.1c,2 b,3a B. 1a,2 b,3c C. 1a,2c,3b D. 1c,2a,3 b E.1b,2 a,3c

32. “Гэв гэнэт хашгирав” өгүүлбэрийн онцолсон үгийг зөв бичсэнийг олоорой.

A. 
 B. 
 C. 
 D. 
 E. 

33. “Би отгондоо илүү их хайртай” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг хэрхэн бичих вэ?

A. 
 B. 
 C. 
 D. 
 E. 

34. “” гэсэн бичлэгт тохирох үг аль нь вэ?

A. хороох цөөлөх B. гар хуруу C. ахмадын хороо
 D. хурга ишиг E. адуу хураа

35. Уншихдаа онцолсон үгийн бичлэгийг ажиглаад, бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.

A. B. C. D. E.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ..

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ..

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ..

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ..

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ
 ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ..

ХОЁР ДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Хэлцийг утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|------------------------------|--------------|
| a. хонь шиг /хүн/ | 1. гадуурхах |
| b. үнсэнд хаясан шалз шиг | 2. хайрлах |
| c. нойтон хамуу шиг | 3. сандрах |
| d. утсан чинээ улаан гол шиг | 4. номхон |
| e. амь наана, там цаана | 5. хурдан |

2.2. “Монголын нууц товчоо” зохиолын эшлэлийг хам сэдэвтэй зөв харгалзуулаарай.

- | | |
|--|------------------------------|
| a. Хулгана жил /1228/ Хэрлэний Хөдөө аралд хурж,
Чингис хааны гэрээсэлсэн ёсоор Өгөөдэйг хаан
өргөмжлөв. | 1. Нийгмийн /ахуй/ хам сэдэв |
| b. Хасар, Тататунгааг багш барин, бичиг хууль цэргийн
бодлого тэргүүтэн олон зүйл бичиг заалгаж,
удалгүй сурав. | 2. Улс төрийн хам сэдэв |
| c. Тэмүүжин өөрөө Бурхан халдун дээр бууж, бүсээ
хүзүүндээ эрх мэт өлгөж, малгайгаа гарт сэгэлдэрч,
гараараа өвчүүгээ даран, наран өөд хандаж, Бурхан
халдунд есөнтөө сөгдөж, өчил өчин, сацал сацав. | 3. Шашин шүтлэгийн хам сэдэв |
| d. “Боорчи баруун гарын түмнийг захирах ноён болов.
Мухулай го ван болж зүүн гарын түмнийг захирах
ноён болов. Одоо Наяа төв түмнийг захирах ноён | 4. Түүхийн хам сэдэв |

болтугай” гэж зарлиг болов.






е. Сорхоншарын гэрийн тэмдэг нь шөнө турш үүр
цайтал сүү самарч, эсэг/айраг/-ээ бүлэх бүлгээ.

5. Соёлын хам сэдэв

2.3.Зөвийг нь олж сонгоорой.

		1.	2.	3.
a	Балархай эгшиг гээгдэхгүй үг	будаг+ийг	чадвар+ыг	бурхад+ыг
b	“е”-г шууд залгаж бичих үг	үзүүл+е	шийд+е	түгээ+е
c	Зөөлний тэмдэг “и” болох үг	сахь+жээ	барь+даг	харь+зна
d	Эр үгэнд “ы” бичих үг	зохиомж	харуул	нутаг
e	“-л” залгавар залгахад урдаа эгшигтэй бичих үг	давхар	төл	нөөц

2.4.Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- a.  1. дал дал хийх
b.  2. дал мод
c.  3. тал газар
d.  4. дал /тоо/
e.  5. дал мөр

СОНСОХ ДААЛГАВАР

Гүйцэтгэх хугацаа: 15 минут [10 оноо]

Санамж:

- Эхийг сонсохын өмнө асуултыг уншаарай.
- Эхийг анхааралтай сонсоод асуултад хариулаарай.
- Хариултын хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудасны /36-40/ зааврын дагуу будаарай. Хариулт бүр 2 оноотой.

36. “би” баатрын балчирхан бага насны мөрөөдлүүдээс “гар нь ганзаганд, хөл нь дөрөөнд хүрэх” гэсэн хэлцтэй дүйх утгатайг нь сонгоорой.

- A. Нутаг дээрээ өрөөстэй нь орхисон чулуун тоглоомоор тоглох
B. Чихэр жимс, бал бурмыг авчирч, айл саахалтынхандаа түгээх
C. Цэнхэр уулсын чанадад хот гэж нэг ариун дагшин оронд очих
D. Үдэш шандан дээр очиж, морио услаад, онгоцоо усаар дүүргэх
E. Хурдхан шиг өсөж, тэнгийн булан даахуйц эр болох

37. Нүүдэлчдийн ахуй амьдралыг аль өгүүлбэрт дүрсэлсэн байна вэ?

- A. Хаврын их нүүдэл аараг борхон толгодын шилээр дэнхэн данхан давна.
B. Тэр үед хот ороод буцаж ирэхийн тухайд санаж явснаас биш шингэнэ гэж бодоогүй.
C. Зарим нь арав хорин жил зэргэлдээ аж төрсөн хэрнээ бие биенээ таньдаггүй.
D. Дөчин насны дөрөөнд гишгэсэн ч өөрийгөө хөдөөгийн хүүхэд гэж бодож явдаг
E. Би он цагийн урсгалд хөдөөгийн ааш араншингаа сэвтүүлэхээс эмээдэг.

38. “би” баатар нь хотынхон хөдөө нутгаараа бахархахгүй байгаагийн гол учрыг юу гэж дүгнэсэн бэ?

- A. Чөлөөтэй нэг сайхан эргэцүүлэн бодох завгүй тул
B. Ном эрдэмд сэтгэлээ зориулсан юм үзэж, нүд тайлсан тул
C. Нүдээ гөлөртөл цангасан малд ганц ховоо ус хийж өгч үзээгүй тул
D. Гоёж гооддог шигээ өнгө хуурамчхан зантай, атаа жөтөөч хүмүүс тул
E. Арав хорин жил нэг байшинд аж төрсөн хэрнээ бие биенээ таньдаггүй тул

39. Хөдөөгийн хүүхдийн араншинд **хамаарахгүй** нь сонгоорой.
- А. Эрт ухаажиж, чулуу таалцахын оронд чөдөр зангидаж сурсан.
 - В. Өртөг өнгө хоёр шингэсэн оньсон тоглоомоор тоглож өссөн.
 - С. Үг яриа нь хүртэл төвшин, сонсголонтой, элдэв гоёл чимэггүй.
 - Д. “Мал ирж юу магад уу” гэж бодоод, онгоцоо усаар дүүргэж орхидог.
 - Е. Боргоцой бяцхан гартаа харандаа барьж, дэнгийн гэрэлд үсэг холбож суусан
40. “Өөрөөсөө байн байн эрж, өврөө тэмтэрч үзээд байдаг” зүйл нь юу вэ?
- А. Чулуун тоглоом
 - В. Чихэр жимс, бал бурам
 - С. Өнчин ишиг
 - Д. Хэлхсэн бодол
 - Е. Хөдөөгийн араншин